



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 234

Улаанбаатар хот

### 「 Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцаас санхүүжүүлэн барьж ашиглалтад оруулсан нийт 149,711,550.00 (нэг зуун дөчин есөн сая долоон зуун арван нэгэн мянга таван зуун тавин) төгрөгийн үнэ бүхий барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу Увс аймгийн (орон нутгийн) өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цогтсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг тус тус даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, байнгын ашиглалтад хүлээн авч, эзэмшигчийг тогтоож (Зүүнхангай сумдын Засаг даргын Тамгын газарт) бүртгэх асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005473  
14-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн  
234 дүгээр тогтоолын хавсралт



Увс аймгийн орон нутгийн өмчид бүртгэх үл хөдлөх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр, байршил	Барилгын хүчин чадал	Гүйцэтгэлээрх дүн /төгрөгөөр/	Улсын комиссын актын дугаар
1	Ахмадын хөгжлийн төв барилга /Увс аймаг, Зүүнхангай сум, Жаргалант баг/	1 давхар, нийт 120м2	149,711,550.00	2022-12-09 УЖД-51/2022
	<b>Нийт дүн</b>		<b>149,711,550.00</b> <b>(нэг зуун дөчин есөн сая</b> <b>долоон зуун арван нэгэн</b> <b>мянга таван зуун тавин)</b>	